

**БОЛЬШЕВИКУУД МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ ШАШНЫГ УСТГАХААР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО (1921-1939)**

*Харнүүд З.Лонжийд (Ph.D, профессор)*

**Түлхүүр үгс:** хүрээ хийд, лам нар, татвар, улс төрийн эрх, хядлага, атеист, татвар, большевик

**Төвч утга:** Зөвлөлт засгийн удирдлага буюу большевикууд Монголд эрхиээлээ тогтоох зорилгоор 1921-1939 онд монголчуудын уламжлалт шашныг устгахдаа харилцан хамааралтай гурван цогч арга хэрэглэсэн тухай хураангуй өгүүлэв.

\* \* \* \* \*

**Эхлэл**

Большевикууд 1917-1929 онд Хаант Оросын олон үндэстний итгэл үнэмшил болсон Загалмайтны (христ, католик, протестант, үнэн алдартан) шашин, Исламын шашин халимаг, буриад, Тагну-ын урианхайчуудын хэдэн үеийн шүтээн буддын шашныг устгажээ. Тэд 1850 -иад оноос эхлэн Хаант Орос улс Монголыг Манжаас салгаж өөртөө нэгтгэх бодлого зугуухан хэрэгжүүлж байсныг хэвээр нь үргэлжлүүлсэн юм. Тэгэхдээ нэн түрүүнд монголчуудын эв нэгдэл, үндэсний үзлийн баталгаа болдог уламжлалт шашныг устгахгүйгээр Монголыг эрхшээн дарангуйлах буюу өөрөөсөө бүрэн хараат болгох боломжгүйг большевикууд мэдэж байв. Иймээс уул бодлогоо 1921-1939 онд бүрэн хэрэгжүүлсэн юм. Гэхдээ бүх монголчуудыг атеист болгож чадаагүй байна.

Тэд эхний шатандаа монголчуудын шашныг дээд зэргээр дэмжиж байгаа мэт хуурмаг дүр эсгэж бид Монголын шашин үндсийг сэргээн мандуулна, бүх зүйлийг чинь сайн сайхан болгоно хэмээн зай завсаргүй тунхаглаж ухуулж сурталчилж ятгаж байлаа. Гэвч олон жил хэдэн үеэрээ харийнханд хууртаж хаширсан Монголын егзэр өвгөчүүд большевикуудад итгэхээсээ илүү болгоомжлох байдалтай байсан бол бурхны шашны лам хуврагуудын дийлэнх нь шашин, үндэс тэс өөр оросууд бидний улсыг дэвжин дээшлэхэд үнэн санаанаасаа туслах эсэхэд эргэлзэж байв. Энэ нь ч зохих шалтгаантай байлаа. Тухайлбал: Оросын харьят буриадууд үймээн самуунаас дүрвэн Монгол руу олноороо ирээд большевикуудын тухай ярьж болгоомжлуулж байсны сацуу Улаан орост болж буй аймшигийн талаар Хятадын Засгийн Газар Монголыг Орост алдчихгүй өөртөө нэгтгэхийн тулд улаан большевизмын аюулыг өргөнөөр сурталчилж байлаа. Мөн Монголын умард хязгаарын Оростой хил савалдаг нутгийн ардууд большевикуудын их хядлагыг мэдэж байлаа. Ийнхүү Зөвлөлт Засгийн газар хаан эзнээ, хатан үр хүүхэдтэй нь хамт хүйс тэмтэрч шашин мөргөлийн шүтээн сүм дуган, бусад бүх хөрөнгийг төрийн өмч хэмээн булааж нэр хүндтэй санвартнуудаа үгийн муугаар гутаан доромжилж зарим нэгийг нь төрд тэrsэллээ хэмээн зарлаж цаазаар авч эхэлснийг монголчууд аль хэдийнээsonсож мэдсэн байв. Энэ бүхэн нь монголыг эрхшээх тэдний холын санаархалд зайлшгүй саад учруулахыг большевикууд ухаарч монголчуудад найрсаг хандаж аль болох аятай эвтэй байхыг хичээсээр 1921 оныг дуусгасан юм.

Ингээд 1922 оноос эхлэн большевикуудын зэс цухуйж Монголын уламжлалт шашныг устгахдаа харилцан сүлжилдсэн гурван цогц арга хэрэглэсэн юм. Тэдгээрээс

хамгийн тулхүү хэрэглэсэн арга нь хядаж егүүтгэж цөлөх, хоёрдахь нь улс төрийн эрхийг нь хасах, гурав дахь нь эдийн засгийн хүчирхийлэл байлаа.

### **Нэг. Хядлага, егүүтгэл**

1922 он гарангутуут большевикуудын зэс цухуйж Монголын лам хуврагуудыг хувьсгалын дайсан хэмээн зайд завсаргүй донгодож лам асан өрөнхий сайд Бодоо, хааны шадар сайд Чагдаржав, Богдын итгэлтэй түшиг бөгөөд хятадын түрэмгий цэргийг монголоос үлдэн зайлзулахад хоёргүй сэтгэлээр чармайн зүтгэсэн түвэд лам Жамъянданzan нарыг гэм зэмгүй арав гаруй хүний хамт цаазлан хороосон юм.

Энэ нь шинэ Монгол улсад 70 жил үргэлжилсэн хавчлага егүүтгэлийн эхлэл байв. Большевикууд ингэж Бодоо нарыг егүүтгэснээрээ монголчуудыг ялангуяа өөрсдөд нь үл итгэгчдийг сүрдүүлж дахин ам ангайхгүй болгож чадна хэмээн итгэлтэй байлаа. Гэвч тэдний горьдлого талаар өнгөрсөн юм.

Иймээс большевикууд монголчуудыг өмнөө сөхрүүлэх бат найдвартай арга олох хэрэгтэйг юуны өмнө ухаарч хүн ардыг нь эв нэгдэлгүй, итгэл бишрэлгүй өвөр зуураа сөргөлдөн тэрслэгчид болгохоор шийджээ. Ингээд Монголын бурхны шашны өндөр нэр хүндтэй хутагт хувилгаадаас эхлээд эгэл жирийн санвартныг хамруулж тэд бол цөм сорон мөлжигч шар хувалз хэмээн тунхаглаж лам хуврагуудыг шавь нараас нь хөндийрүүлж өргөн түмнээр жигшүүлэхийг хичээсэн юм. Гэвч монголчууд уламжлалт шашиндаа үнэнч хэвээр байлаа. Иймээс зөвхөн гүтгэн доромжлох нь явцгүй учир хядлагатай хослуулахаар шийдвэрлэж 1922-1939 он дуусталх хорь хүрэхгүй жилийн хугацаанд хоёр түм гаруй ламыг цаазалж тэдний төрөл садан, номын шавь хэдэн мянган хүнийг егүүтгэж шорон гянданд хорьсон юм. Ингэж большевикууд монголчуудын уламжлалт шашныг устгахдаа цуст егүүтгэлийн аргыг тулхүү хэрэглэсэн билээ.

1922-1939 онд большевикуудын санаачлага, заавар, чанд хяналтын дор хэрэгжүүлсэн их хядлагад манай улсын чухам хэдэн хүн өртсөнийг бид эдүгээ хүртэл ойролцоогоор гаргаж чадаагүй бөгөөд энэ бол хэзээ ч үл биелэх нь тун ойлгомжтой. Большевикууд монголын санвартнууд болон өөрсдөд нь бөхөлзөөгүй олон хүнийг цаазлахын сацуу харьд цөлж Оросын тэсгим хүйтэн хязгаарт аваачиж амь дүйсэн хүнд ажилд зүтгүүлж байлаа. Түүхийн амьд гэрч болсон баримт сурвалжийг ажиглаж байхад большевикууд монголчуудыг залхаан цээрлүүлэхдээ маш нарийн данс бүртгэлтэй байсан нь мэдэгддэг. Гэвч тэд үйлдсэн данс хараагаа байнга устгаж байсан учир эдүгээ юунд олдох билээ. Жич, Большевикуудын үйлдсэн егүүтгэлийн ул мөрийг нэхэн тодруулахад дөхөм болохуйц цөөнгүй баримт сурвалж манай улс болон ОХУ-д байдаг боловч өнөөдөр судлаачид уншиж танилцахыг зөвшөөрөхгүй байдаг нь ямар учиртайг тааварлах аргагүй байна. Хэрэв энэ талаар тодорхой мэдэхийг хүсэгчид байвал би болон надтай хамт ажилладаг хүмүүс бодитойгоор нотлож ярьж чадна.

### **Хоёр. Улс төрийн эрх хасахуй**

1924 онд баталсан Үндсэн хуульд лам санвартнуудыг жинхэнэ бус ард хэмээх цоо шинэ ангилалд хамруулж тэдний улс төрийн эрхийг хассан юм. Үүний улмаас 1924-1944 оны намар хүртэл бүтэн 21 жилийн турш санвартнууд сонгох сонгогдох эрхгүй байлаа. Гэвч лам санвартнууд улс төрийн эрхээ хасууллаа хэмээн гутаж гуньсангүй харин ч улаантны харгис засгийн элдэв хэрэгт оролцохгүй болсондоо сэтгэл хангалиун байсан бололтой. Тиймээс тэд бараг цөмөөрөө улс төрийн эрх олгож өгөөч хэмээн большевикуудаас огтхон ч хүсээгүй юм билээ.

Тэд ёсоо сахьсан санвартны хувьд шашин номын үйлсдээ чин үнэнч байхыг л эрхэмлэхээс өөр илүү зүйлд шунаагүй ажээ.

Большевикууд лам нарын улс төрийн эрхийг хассан атлаа тэднийг МАН (1925 оноос МАХН)-ын гишүүнд чанд болзол хяналттайгаар элсэхийг 1921-1928 онд зөвшөөрч байлаа. Гэвч өөрийн сайн дураараа намын гишүүнд элссэн лам тун цөөхөн байжээ. 1928 оны эцсээр тэд МАХН ба Монголын төрийн удирдлагад өөрсдийн итгэлтэй хүмүүсээ томилсны дараа 1929 оноос лам нарыг МАХН-ын гишүүнд элсүүлэхгүй хэмээн шийдвэрлэсэн юм.

Большевикууд лам хуврагуудын улс төрийн эрхийг хассан нь уламжлалт шашныг устгахад дорвитой тус дөхөм болоогүй юм билээ.

### *Гурав. Эдийн засгийн хүчирхийлэл*

Большевикууд Монголын бүх лам хувраг, өөрсдөд нь таагүй ханддаг хүн бүрийг хядаж дуусгах боломжгүй байлаа. Тиймээс шашныг устгахдаа эдийн засгийн хүчирхийлэл буюу санхүүгийн дарамтыг хавсарга болгон 1922-1938 онд 15 жилийн турш хэрэгжүүлсэн юм. Энэхүү хүчирхийлэл нь дотроо хэд хэдэн чиглэлтэй байв. Үүнд 1-рт жасын татвар 2-рт лам нарын ашиг орлогын татвар 3-рт дуган сүм, хийдийн бурхан тахилшүтээн, байшин барилга буюу үл хөдлөх хөрөнгийн татвар 4-рт өндөр ашиг орлоготой хэргэм зэрэг мяндаг тушаалтан, хутагт хувилгаадын татвар 5-рт ид залуу цэргийн насны лам нараас хураах цэргийн татвар гэж таван төрөл байжээ.

### *Жасын татвар*

1922-1925 онд хүрээ хийдийн аж ахуй-жасын мал сүрэг, тариалангаас өсгөн нэмэгдүүлэх татвар хурааж байсан бол 1926-1930 онд улсын албан татварын нэгдсэн хуулийн заалтаар; 1931-1937 онд жас, лам нарт татвар хураамж ногдуулах хэд хэдэн шийдвэр гаргасан юм. Мөн жасууд мал сүргээ баян чинээлэг хүмүүсээр маллуулахыг хориглож зөвхөн ядуучууд эсвэл шинэ тутам үүсэн байгуулагдаж байсан таван янзын хамтын аж ахуйгаар маллуулах шийдвэрийг 1930-1937 онд албадан хэрэгжүүлсэн юм.

Энд нэг зүйлийг товч тодруулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Тухайлбал, жасууд 1700-гаад оноос хойш мал сүргээ бусдаар маллуулахдаа заавал бэл бэнчинтэй баян хүмүүсийг сонгодог байв. Энэ нь баян хүн бол ажилсаг бөгөөд жасын мал хариулахаар аваад алдаж үрэгдүүлбэл төлөөд өгөх бүрэн боломжтой байв. Жасууд малаа бусдаар маллуулахдаа тусгай хөлс төлөхгүй буюу мал адгуулагч нь хариулсан малаа тодорхой болзол хэмжээний дагуу өсгөх буюу эсэн мэнд маллах ёстой болзоос илүү гарсныг нь өөрөө авах эрхтэй байв.

Жасуудаас мал адгуулахаар авсан хүн уул малаа цааш нь өөрийнхөө итгэл, найдвартай гэж тооцдог хүнтэй тохирон дам шилжүүлэх эрхтэй байв. Үүнийг дам турээс (subrenda) гэдэг. Жасууд ийм зарчим баримталж байсны үрээр мал сүрэг нь тогтвортой өсөж ашиг орлого нь нэмэгдэж байжээ. Жич жасууд мал сүргээ зүтгэх хүчний мал (шар, ат, агт), эзэмшиж буй тариалангийн талбайгаа ч мөн дээрх аргаар ашиглаж байв. Харин жасууд бэлэн мөнгө-(цэвэр металл мөнгө, гадаад улсын мөнгөн тэмдэгт, томоохон хүрээ хийдийн тийз)-ийг 1921-1928 онд бусдад хүүтэй зээлүүлэхийг төрөөс зөвшөөрч байв. Гэвч үүнийг 1930 онд Намын VIII их хурлын шийдвэрээр хориглосон юм. Энэ бол шашныг устгахад хэрэглэсэн эдийн засгийн албадлагын нэг төрөл билээ.

*Хүснэгт №.1 Улсын хэмжээний бүх жасын малын тоо толгой 1924-1937 онд хэрхэн хорогдсон тухай үзүүлэлт .*

Эх сурвалж. 1. Печников АМ . 1949 т.8

2. Намсрай Д. 1935 т.108

Он	Жасын малын (мянга)	бүх тоо	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1924	2 912,6		41,6	230,4	266,9	Хонь, ямаа 2 373,6	=
1925	2 650,1		45,0	167,5	204,3	Хонь, ямаа 2 233,3	=
1926	3 350,9		52,8	224,9	290,5	2 557,8	224,9
1927	3 598,3		56,2	227,3	248,6	2 822,3	243,8
1928	3 460,1		51,8	218,6	234,4	2 709,7	245,4
1929	3 286,1		42,1	177,7	211,0	2 653,1	202,1
1930	3 034,6		36,1	151,0	164,3	2 412,3	270,8
1931	=	=	=	=	=	=	=
1932	263,1		6,1	2,8	32,0	Хонь, ямаа 196,0	=
1933	392,3		8,3		21,4	305,2	25,7
1934	256,7		5,9		12,2	200,4	17,7
1935	162,5		5,0		8,4	118,0	16,5
1936	108,7		3,8		5,3	76,8	11,7
1937	84,6		3,0		3,7	58,4	10,4

Энэхүү хүснэгтэд жасын малын тоог 1924-1937 оны мэдээнээс авсан бөгөөд зөвхөн 1932 оны малын тоог 1935 онд Д.Намсрайн бичсэн номноос ашиглал. Зарим мэдээгээр бол 1927 онд жасын бүх мал 5 сая байсан гэж дурджээ. (Намын ... 1932 т.37). Энэхүү хүснэгтээс ажиглахад 1927 онд жасын мал 3 598,3 мянга байсан нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд үүнээс хойш жасын мал жил дараалан хорогдоор 1937 оны эцэст 84,6 мянга болж 1927 оныхоос 3 513,7 мянгаар буюу 42,5 дахин хорогдож байжээ. Гэтэл энэ хугацаанд улсын хэмжээний бүх мал 2 018,2 мянгаас 2 338,3 мянга болж 3 сая 199 мянгаар буюу 9,99-иар өсчээ. (Печников АМ . 1949 т.6) Жасын мал ийнхүү эрс хорогдсон нь 1928 оны эцсээс 1932 оны зун хүртэл үргэлжилсэн зүүнтний үед МАХН-аас Шашныг устгах

бодлого хэрэгжүүлэхдээ лам нарыг үй олноор нь баривчилж цаазлах шорон гянданд хорихыг эдийн засгийн хүчирхийлэлтэй хослуулан довтолсны уршиг байв.

Энэхүү хүснэгтэд буй 1927-1937 оны статистикийг ажиглахад 1927-1930 онд жасын мал 3 598,3-аас 3 034,6 болж 563,7 мянгаар буюу нэг жилд дунджаар 187,9 мянгаар хорогдож байжээ. Гэтэл 1930-1932 онд 3 034,6 мянгаас 263,1 мянга болж 2 771,5 мянгаар буюу 11,5 дахин цөөрчээ. Энэ нь нэг жилд 1,5 сая мал хорогсоныг харуулж байна.

Зүүнтнүүд МАХН-ын VIII их хурлын шийдвэрийн дагуу хүрээ хийдийг санхүүгийн хувьд боомилохын тулд жасын кампанийг 1929 оны эцсээс 1932 оны 6-р сар хүртэл зохион байгуулж жасын малыг хамтран, коммуна, артель, нэгдэл, нөхөрлөлөөр өндөр хөлстэй маллуулах болжээ. Иймээс жасууд сүргээ маллуулсны хөлсийг төлөхийн тулд малаа хямд үнээр олон толгойгоор нь худалджээ. Үүнээс гадна жасын сүрэг адгуулагчид уул малаасаа алдах, чоно, араатанд идүүлэх, үхлээр хорогдуулбал төлөхийг хэрэгсэхгүй болгосон байв. Зүүнтнүүд зориуд ийм түрэмгий бодлого хэрэгжүүлсний уршигаар хүрээ хийдүүд 1937 оны эцэст мөнгө санхүүгийн хувьд сөхөрч үйл ажиллагаагаа зогсоохоос өөр аргагүй болжээ.

Зүүнтнүүд Монголын уламжлалт шашныг устгах зорилгоо биелүүлэхийн тулд лам санвартнуудыг дээд, дунд, доод хэмээх гурван анги зэрэг болгон хувааж доод ангийн лам нарыг татвараас чөлөөлждээд ангийн лам нараас олз ашгийн татвар эд хөрөнгийн татварыг их хэмжээгээр ногдуулан хураажбайв. Мөн дээд, дунд ангийн лам нар цэргийн алба хаахыг хориглож тэднээс их хэмжээний татвар хурааж байв. Зүүнтнүүд Монголын уламжлалт шашныг эдийн засгийн албадлагаар сөхрүүлэхдээ хэрэглэсэн бас нэг арга бол үл хөдлөх хөрөнгийн татвар байлаа.

1927 оны сүүлчээс эхлэн бүх хүрээ хийдийн байшин барилга (сүм дуган)-д үнэ тогтоож тодорхой хувьтай нь тэнцэх татварыг 1938 оны эцэс хүртэл хураасан юм. Гэхдээ аймаг, хот, улсын хэмжээний нэгдсэн дун мэдээ одоогоор оддохгүй байна. Үүнийг эрж олохын тулд Сангийн яам, зарим аймаг, Улаанбаатар хотын санхүүгийн тайланг шүүрдсэн боловч тодорхой зүйл олдсонгүй. Үүнтэй холбогдуулж хэлэхэд өргөн цар хүрээтэй зарим сэдэв асуудлыг нэхэн шинжилж судлахад ганц хоёр хүн хичнээн мэрийж чармайвч олигтой үр дунд хүрэх магадлал бага юм. Харин мэргэжлийн судлаачидтай баг ажиллавал тодорхой ахиц гарах нь лавтай билээ. Төрөөс хүрээ хийдийн үл хөдлөх хөрөнгө жасын мал сүрэг, лам нарт ногдуулсан татварыг заасан хугацаанд нь бүрэн төлж амжаагүй бол эрүүгийн хуулиар ял ногдуулж, татварын дутууг хэд дахин нугалж заавал төлүүлж байжээ.

Большевикууд монголын уламжлалт шашныг устгах явцаа түргэгэхийн тулд дээр дурдсан гурван цогц бодлогоос гадна нэгэн шинэ зүйлийг 1936 онд сэдсэн юм. Тэр нь юу байсныг товч өгүүлье. Үүнд 9-р Банчин Эрдэнэ Чойжинням (1883-1937)бээр 13-р Далай лам Түвдэнжамцтай үзэл бодол таараагүйн улмаас Хятадад дүрвэн ирж 1924-1937 онд Өвөр Монгол, Барга, Цахараар морилж сүсэгтнүүдэд ном айлдаж байв. Үүнийг ажиж мэдсэн манай улсын зарим иргэд 1927-1928 онд зохих зөвшөөрөл (виз) авч хил нэвтрэн Банчин Эрдэнэд бараалхан нүглээ наманчлахын сацуу большевикуудын дарангуйллаас ангижрахад дэмжиж туслахыг хүссэн байхыг үгүйсгэх аргагүй. Тиймээс большевикууд Банчин Эрдэнийн нөлөөнөөс сэрэмжлэх нэрийдлээр суртал ухуулгын сацуу зарим хүрээ хийдийг нүүлгэхээр шийдвэрлэжээ. Уг шийдвэрээр одоогийн Дорнодооос Ховд хүртэл Монголын зүүн өмнө, өмнө, баруун өмнө хилд ойролцоо 16 хүрээ хийдийг маш цөөхөн хоногийн дотор нутгийн гүн лүү шилжин байрлахыг шаардсан юм. Гэвч жас, лам

нарынхаа татварыг төлөхийн тулд хамаг хөрөнгөө шавхсан тэдгээр хүрээ хийд уг заасан хугацаанд нүүж амжихгүй учир лам хуврагууд нь шууд хүрээ хийдээ хааж арга буюу харын дансанд шилжсэн юм. Тэдгээр 16 хүрээ хийдийн зарим нь монголд төдийгүй олон улсад танигдсан нэр хүндтэй байв. Тухайлбал Амарбуянт, Егүзэрийн хийдийг Монголд төдийгүй Түвшэд, Хятадад олон хүн мэддэг байсан билээ.

### Төгсгөл

Большевикууд 1921-1939 онд монголчуудын уламжлалт шашныг устгаж ард иргэдийг нь атеист үзэлтэй болгохын тулд боловсруулж хэрэгжүүлсэн бодлогын агуулгыг энэхүү илтгэл хураангуй өгүүллээ.

Тэд боловсруулсан бодлогоо хэрэгжүүлэхдээ гурвалсан буюу нэг нь нөгөөгөө нөхвөрлөсөн уграа аргыг хэрэглэжээ. Тэрхүү бодлогыг эсэргүүцэж 1926-1931 онд Монголын хэд хэдэн нутагт бослого дэгдсэн боловч тухай бүрд нь хэрцгийгээр дарж байлаа. Гэвч монголчууд шантарсангүй 1932 онд нилээд олон, хүн өргөн газар нутаг хамарсан их бослого дэгдсэн боловч орос монгол цэргийн хамтарсан хэт давуу хүчний өмнө арга буюу сөхөрсөн юм. 1932 оны зэвсэгт бослого зохион байгуулагчид гаднаас ямар ч тусламж дэмжлэг аваагүй байна. Гэтэл 1990 оноос өмнө харийнхны заавраар бичиж боловсруулж тэдний чанд хяналтын дор хэвлүүлсэн сурталчилгаа судалгааны бүтээлүүдэд 1932 оны зэвсэгт бослого нь Банчин Эрдэнийн удирдлага заавраар дэгдсэн хэмээн дурдсан байдаг. Энэ нь ор үндэсгүйг 1990 оноос хойшхи судалгаа нотолж байдаг боловч Монголыг ЗХУ-аас бүрэн хараат байх үед Улсыг аюулаас хамгаалах байгууллагад олон жил хариуцлагатай алба хашсан зарим хүн эдүгээ ч дээрх гүтгэлгийг туйлын үнэн хэмээн бүх боломжийг ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бүтээл туурвидаа дахин дахин тэмдэглэсээр байгааг плюрализм бодитой хэрэгжиж буйн нотолгоо хэмээн үл ажрах нь байж боломгүй зориуд тэмдэглэе.

### НОМ ЗҮЙ

1. Намын ... 1932-Намын сургууль 2 дугаар дэвтэр УБ.,1932
2. Намсрай Д 1935 –Одоо үеийн Монгол Ард Улсын доторх лам нарын асуудлын тухай Дотоодыг Хамгаалах Газрын дарга Намсрайн бичсэн номын эх –YTA-УТНОНБТ. 4-5-106.
3. Печников А.М. Животноводство МНР Материалы государственной статистики. Выпуск 1 УБ.,1949.
4. Тойнби А.Ж. Түүх судлал УБ.,2007

### ABSTRACT

There are numerous examined subjects in the study of XX century Mongolian history. One of them is the Bolshevik policy that was systematically implemented in sequential phases to integrate Mongolia, a country of immense resources and vast lands, into them having absolute power over the nation. Mongolian Buddhism was a first Bolshevik target because of its deep root in Mongols' long-established nationalism, cultural values and practised rituals; the Bolsheviks wished to nullify them all in shortest possible time. The Bolsheviks believed the continued application of brutal violence along with economic repression will crush Buddhism in Mongolia degenerating the nation's spirit in their faith, morality and independence so that they can rule the

country in favour of them without any opposition. A big picture of the Bolshevik policy enforcement 1921-1939 is discussed here on the grounds of historical resources.